



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд,
түүнийг тооцох аргачлал батлах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Үндэсний статистикийн хорооны Даргын зөвлөлийн 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, түүнийг тооцох аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан аргачлалын дагуу үзүүлэлтийг тооцож, ажиллахыг Үндэсний тооцоо, шинжилгээ, судалгааны газар /А.Дэмбэрэл/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т даалгасугай.

ДАРГА



А.АРИУНЗАЯА

Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны
07-р сарын 03-ны өдрийн А/103 тоот тушаалын
хавсралтаар батлав.



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

НОГООН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Улаанбаатар 2017 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
II. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	6
III. ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖАГСААЛТ	8
IV. ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР	10
4.1. Эдийн засгийн үзүүлэлтүүд	10
4.2. Нийгмийн үзүүлэлтүүд	14
4.3. Байгаль орчны үзүүлэлтүүд	16
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	27
Хавсралт 1.	29
Хавсралт 2.	34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОЭЗД	Байгаль орчин, эдийн засгийн данс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮББОХ	НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр
НҮБСХ	НҮБ-ын Статистикийн хэлтэс
НЭЗТТ	Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХХҮТ	Хүлэмжийн хийн үндэсний тооллого
ТБХ	Талуудын бага хурал
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дэлхий нийтэд байгаль орчинд үзүүлэх хүний үйл ажиллагааны нөлөөлөл нь хамгийн чухал бодлогын асуудлуудын нэг болоод байна. Иймээс улс орон бүр өөрийн үйлдвэрлэл, хэрэглээнийхээ хэв маягийг өөрчилж, байгальд ээлтэй загварт шилжиж байна.

НҮБ-ын “Rio+20” тогтвортой хөгжлийн чуулганаар “Бидний хүсч буй ирээдүй” тунхаглалд тогтвортой хөгжилд хүрэх, ядуурлыг бууруулахад “ногоон эдийн засаг” гол хөдөлгүүр байна хэмээн онцлон тэмдэглэсэн. Мөн НҮБ-ыг ногоон эдийн засагт шилжихийг зорьж буй улс орнуудад дэмжлэг үзүүлэхийг уриалсан. Ийнхүү уг чуулганаар “Тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах ногоон эдийн засаг”, “Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээ” хэсэгт ногоон эдийн засаг, ногоон өсөлтийн талаар хэлэлцэн НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ)-ийг санаачилсан.

Манай улс 2013 онд Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийг дэмжиж, Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (НЭЗТТ)-д нэгдсэн. Улмаар “Ногоон хөгжлийн бодлого”-ыг тодорхойлж, Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 тоот тогтоолоор; бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗГ-ын 2016 оны 35 тоот тогтоолоор батлуулсан.

Мөн НҮБ-ын Статистикийн хэлтэс (НҮБСХ)-ээс хөгжиж буй орнуудын ногоон эдийн засгийн өнөөгийн түвшинг үнэлэх, шилжилтийн явцыг хянах, ногоон өсөлтийг хэмжих үзүүлэлтийг тодорхойлох “Ногоон эдийн засагт шилжих явцыг үнэлэх нь” төслийг хэрэгжүүлэх Азийн бүсийн 4 орны нэгээр Монгол Улс (ҮСХ) сонгогдон ажилласан.

Түүнчлэн, Монгол Улс нь “Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллага”-ын гишүүн орны хувьд ногоон хөгжлийн бодлогыг дэмжсэн үйл ажиллагаанууд зохион байгуулагдаж байна.

Монгол Улс ногоон хөгжлийн бодлогоо томъёолж, улмаар ногоон хөгжлийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, тооцох аргачлалыг олон улсын арга зүйд нийцүүлэн боловсруулах, үзүүлэлтийн системийг бий болгох ажлыг хийж байна. Үүний дүнд ногоон эдийн засаг/хөгжлийг тодорхойлох, цаашилбал, ногоон хөгжлийн загварт шилжих зөв зохистой арга хэрэгсэл, ногоон хөгжлийн үе шатыг үнэлэх, хүрэх түвшинг тодорхойлох боломж бүрдэх юм. Мөн ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийн гарааны түвшинг зөв тооцох боломж бүрдэнэ.

НҮБСХ, НҮББОХ, ЭЗХАХБ-аас боловсруулсан ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлт, түүний хамрах хүрээтэй нийцүүлэн улмаар өргөн хүрээг хамарсан уулзалт, хэлэлцүүлэг, үйл ажиллагааны үр дүнд үндэсний түвшинд өөрийн орны “Ногоон

хөгжлийн бодлого"-той уялдуулсан Монгол Улсын ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтүүдийн төслийг боловсруулж, нэн тэргүүнд тооцох 30 гаруй үзүүлэлтийг тодорхойлж, одоогоор тооцох боломжтой үзүүлэлтүүдийг энэхүү аргачлалд тусгав. Одоогоор арга зүй, мэдээллийн эх үүсвэр нь тодорхойгүй дараах үзүүлэлтийг арга зүй, мэдээллийн эх үүсвэрийг үе шаттайгаар цаашид бий болгоно. Үүнд:

Эдийн засгийн үзүүлэлт:

1. Ногоон болон тогтвортой хөгжил дэмжсэн худалдан авалтын төрийн нийт худалдан авалтанд эзлэх хувь
2. Барилгын дулаан алдагдлын бууралтын хувь
3. Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зорчигчдын нийт зорчигчдод эзлэх хувь
4. Нийт тээврийн хэрэгсэлд ногоон нийтийн тээврийн хэрэгслийн эзлэх хувь

Нийгмийн үзүүлэлт:

5. Ногоон ажлын байрны тоо

Байгаль орчны үзүүлэлт:

6. Дотоодын нийт бүтээдэхүүнд ногдох материалын нийт ул мөр (footprint)

II. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Нүүдлийн уламжлалт соёл, иргэншилд суурилж, үр ашиг өндөртэй орчин үеийн технологиор үйлдвэрлэлээ дэмжиж, ногоон эдийн засагт шилжих хөгжлийн чиг хандлагыг Монгол Улс тодорхойлоод байгаа бөгөөд түүнийг үнэлэх үзүүлэлтийг тооцоход дараах нэр томъёог ашиглана. Үүнд:

Ногоон эдийн засаг гэж байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгах замаар хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг ойлгоно.¹

Ногоон хөгжил гэж байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, нийгмийн оролцоог хангаж, ядуурлыг бууруулах хөгжлийн загварыг ойлгоно.²

Ногоон худалдан авалт гэж эрчим хүч, байгалийн нөөц баялгийн хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг ойлгоно.³

Ногоон үйлдвэрлэл гэж эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ойлгоно.

Ногоон барилга гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг ойлгоно.

Ногоон нийтийн тээврийн хэрэгсэл гэж уламжлалт дотоод шаталтын хөдөлгүүрт ашигладаг бензин, дизелиэс өөр төрлийн түлшийг хэрэглэх, эсвэл тээврийн хэрэгслээс ялгарч буй утаа, тортогжилтыг бууруулах нэмэлт тоног төхөөрөмжийг суурилуулан байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан нийтийн тээврийн хэрэгслийг ойлгоно.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) гэж тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд

¹ UNEP (2012), Measuring Progress towards an inclusive green economy, хуудас.9

² УИХ (2014), Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, хуудас.3

³ УИХ (2014), Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, хуудас.3

дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээг ойлгоно. Энэ нь улс орны эдийн засгийн үйл ажиллагааны цар хэмжээг харуулдаг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт юм.

III. ҮЗҮҮЛЭЛТИЙН ЖАГСААЛТ

№	Үзүүлэлт	Мэдээллийн боломжит байдал
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД		
1	Эрчим хүчний багтаамж	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
2	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
3	Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний боловсруулалтын хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
4	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Тархаагдаж байгаа
5	Аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
6	Ногоон хөгжил болон байгаль орчныг хамгаалах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
7	Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын Засгийн газрын зардалд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
8	Ногоон болон тогтвортой хөгжил дэмжсэн худалдан авалтын төрийн нийт худалдан авалтанд эзлэх хувь	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
9	Шинжилгээ, судалгаа, хөгжлийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
10	Барилгын дулаан алдагдлын бууралтын хувь	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
11	Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зорчигчдын нийт зорчигчдод эзлэх хувь	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
12	Нийт тээврийн хэрэгсэлд ногоон нийтийн тээврийн хэрэгслийн эзлэх хувь	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД		
13	Ногоон ажлын байрны тоо	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
14	Ажилгүйдлийн түвшин	Тархаагдаж байгаа
15	Хөдөлмөрийн бүтээмж	Тархаагдаж байгаа
16	Ядуурлын хамралтын хүрээ	Тархаагдаж байгаа
17	Ундны баталгаат усаар хангагдсан хүн амын эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
18	Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД		
19	Материал багтаамж	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

Ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийг тооцох аргачлал

№	Үзүүлэлт	Мэдээллийн боломжит байдал
20	Дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох материалын нийт ул мөр (footprint)	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
21	Хүлэмжийн хийн ялгарал	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
22	Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн нийт дүнд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
23	Хатаж ширгэсэн гол, горхи, булаг шанд, нуур тойрмын тоо	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
24	Стандартын шаардлагад нийцэх түвшин хүртэл цэвэрлэсэн хаягдал усны нийт хаягдал усанд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
25	Хот, суурин газрын агаар дах тоосонцорын агууламж (PM10, PM2.5)	Тархаагдаж байгаа
26	Хот, суурин газрын агаар дахь хүхэрлэг хийн агууламж	Тархаагдаж байгаа
27	Хот, суурин газрын азотын давхар ислийн агууламж	Тархаагдаж байгаа
28	Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
29	Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн нийт хот тосгон, бусад суурин газрын талбайд эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
30	Тусгай хамгаалалттай газрын Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
31	Ойгоор бүрхэгдсэн газрын эзлэх хувь буюу ойрхог чанар	Тархаагдаж байна
32	Хохирол учирсан газрын Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тархаагдаж байгаа
33	Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд орсон нутаг дэвсгэрийн Монгол Улсын нийт газар нутагт эзлэх хувь	Тархаагдаж байгаа
34	Нөхөн сэргээсэн хөдөө аж ахуйн газрын хохирол учирсан нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тархаагдаж байгаа
35	Ашигт малтмалын олборлолтод өртсөн газрын хохирол учирсан нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тархаагдаж байгаа
36	Цомхотгосон болон тэг элдэншүүлэгийн технологи нэвтрүүлсэн талбайн хэмжээ үр тарианы нийт талбайд эзлэх	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
37	Бэлчээрийн даац	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
38	Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO-14001 стандартыг хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

IV. ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь албан ёсны статистикийн мэдээллээс гадна статистикийн тооллого, судалгааны мэдээлэл болно. Мөн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын эрхлэн гаргадаг захиргааны статистик мэдээлэл байна.

4.1. Эдийн засгийн үзүүлэлтүүд

1. Эрчим хүчний багтаамж

Үзүүлэлтийн тодорхойлолт: Эрчим хүчний багтаамж нь тухайн улс орны эрчим хүчний хэрэглээний үр ашгийг харуулна. Эрчим хүчний багтаамжийг тухайн жилийн эрчим хүчний дотоодын хэрэглээний ДНБ-д эзэлж буй хувийн жингээр тооцно.

Эрчим хүчний дотоодын хэрэглээ гэж тухайн эдийн засгийн нэгжийн хэрэглэсэн эрчим хүчний хэмжээг ойлгоно. Эрчим хүчний дотоодын хэрэглээг тодорхойлохдоо эрчим хүчний бүтээгдэхүүний эцсийн хэрэглээнээс эрчим хүчний бүтээгдэхүүний экспортыг хасч, эрчим хүчний алдагдал (дамжуулалт, түгээлтийн үеийн алдагдал)-ыг нэмсэнтэй тэнцүү. Эрчим хүчний бүтээгдэхүүнд хатуу түлш, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн (нүүрс, хүлэр, кокс гэх мэт), цахилгаан, дулаан (цахилгаан, дулаан, сэргээгдэх эрчим хүч), био-эрчим хүч, хог хаягдал (хатуу био-түлш, шингэн био-түлш, био-газ гэх мэт), шингэн болон хийн түлш (газрын тос, байгалийн хий, байгалийн шингэн түлш) хамаарна.

$$\text{Эрчим хүчний багтаамж} = \frac{\text{Эрчим хүчний дотоодын хэрэглээ}}{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Энэ үзүүлэлтийг эрчим хүчний дансанд үндэслэн улсын дүн, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, жилээр тооцно.

2. Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Эрчим хүчний суурилагдсан хүчин чадал гэж цахилгааны эх үүсвэрүүд (цахилгаан станцууд)-ийн үйлдвэрлэх эрчим хүчний хамгийн их боломжит хүчин чадлын нийлбэрээр ойлгоно.

Сэргээгдэх эрчим хүч гэж байгаль дээр тасралтгүй нөхөн сэргээгдэж байдаг энергийг ойлгох бөгөөд үүнд нар, салхи, ус, биомасс, далай, газрын гүний дулааны эрчим хүч багтдаг.

$$\frac{\text{Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь}}{\text{Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадал}} = \frac{\text{Эрчим хүчний суурилагдсан нийт хүчин чадал}}{\text{Эрчим хүчний суурилагдсан нийт хүчин чадал}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Уг мэдээллийг Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Эрчим хүчний салбарын жилийн тайлан”-аас улсын дүнгээр, жилээр тооцно.

3. Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний боловсруулалтын хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн гэж эрдэс бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, экспортод 80.0-с дээш хувийг эзэлж буй хүрэн болон чулуун нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибден, гянтболд, цагаан тугалга, цайр, хайлуур жоншийг ойлгоно. Боловсруулсан эрдэс бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлохдоо зэс, молибден, гянтболд, цагаан тугалга, цайр, хайлуур жонш, нүүрсийг баяжуулсан эрдэс бүтээгдэхүүний хэмжээгээр тонноор тодорхойлно⁴.

$$\frac{\text{Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний боловсруулалтын хувь}}{\text{Боловсруулсан эрдэс бүтээгдэхүүний хэмжээ}} = \frac{\text{Нийт олборлосон эрдэс бүтээгдэхүүний хэмжээ}}{\text{Нийт олборлосон эрдэс бүтээгдэхүүний хэмжээ}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: ҮСХ-ны “Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын 20... оны ...-р сарын мэдээ” ААҮ1-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

4. Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хөдөө аж ахуйн салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗҮАСА 4.0)-ын код А буюу “Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур”, аж үйлдвэрийн салбарт тус ангиллын код В буюу “Уул уурхай, олборлолт” С буюу “Боловсруулах үйлдвэрлэл”, D буюу “Цахилгаан, хий, уур, агааржуулалт”, E буюу “Ус хангамж;

⁴ Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал батлах тухай Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоол.

бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа”-ны салбарууд хамрагдана.

$$\begin{array}{l} \text{ХАА, АҮ-н} \\ \text{салбарын} \\ \text{нэмэгдэл өртгийн} \\ \text{дотоодын нийт} \\ \text{бүтээгдэхүүнд} \\ \text{эзлэх хувь} \end{array} = \frac{\text{ХАА, АҮ-н салбарын нэмэгдэл өртөг}}{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн тооцоонд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

5. Аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Аялал жуулчлалын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ЭЗҮАСА 4.0)-ын код 79 буюу “Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа”-ны дэд салбар хамрагдана.

$$\begin{array}{l} \text{Аялал жуулчлалын} \\ \text{салбарын нэмэгдэл} \\ \text{өртгийн дотоодын} \\ \text{нийт бүтээгдэхүүнд} \\ \text{эзлэх хувь} \end{array} = \frac{\text{Аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртөг}}{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн тооцоонд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

6. Ногоон хөгжил болон байгаль орчныг хамгаалах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Байгаль орчныг хамгаалах зардал гэж байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих зэрэг байгаль хамгаалах арга хэмжээнд улсын болон орон нутгийн төсөв болон аж ахуйн нэгж, байгууллагаас зарцуулсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын нийлбэрийг ойлгоно. Тухайлбал, байгаль орчин дахь бохирдол, хог хаягдлыг бууруулах, тэдгээрээс зайлсхийх үйлдвэрлэлийн процесстой холбоотой тоног төхөөрөмжийн зардал, бохирдол асгарах, алдагдахаас сэргийлсэн тоног төхөөрөмжийн зэрэг зардал хамаарна. Харин **НОГООН**

хөгжлийн зардалд ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс зарцуулсан зардал болон ногоон хөгжлийн чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагаас зарцуулсан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардал, ногоон ажлын байрт ногдох үйлдвэрлэлийн болон үйл ажиллагааны зардлыг хамруулна.

$$\frac{\text{Ногоон хөгжил болон байгаль орчныг хамгаалах зардлын ДНБ-д эзлэх хувь}}{\text{Ногоон хөгжил болон байгаль орчныг хамгаалах зардал}} = \frac{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр}}{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн, оны үнээр}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төсвийн багцын байгаль хамгаалах арга хэмжээний санхүүгийн тайлан, яамны үйл ажиллагааны тайлан, Монгол Улсын нийт төсвийн зарцуулалтын тайлангийн хэсэг, Сангийн яам, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Үндэсний хөгжлийн газар, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан”; “Байгаль орчныг хамгаалах зардлын судалгаа”-ны үр дүн, ҮСХ-ны ДНБ-ий тооцоонд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

7. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын Засгийн газрын зардалд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан зардал гэж тайлант хугацаанд улсын төсвөөс гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшиг, аюулт үзэгдэл, осол аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, авран хамгаалах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлыг ойлгоно.

$$\frac{\text{Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын Засгийн газрын зардалд эзлэх хувь}}{\text{Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан зардал}} = \frac{\text{Засгийн газрын нийт зардал}}{\text{Засгийн газрын нийт зардал}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд зарцуулсан Улсын комисс, төрийн байгууллага,

засаг захиргааны нэгжийн болон Онцгой байдлын ерөнхий газрын тайлант жилийн “Санхүүгийн тайланд”-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

8. Шинжилгээ, судалгаа, хөгжлийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Шинжилгээ, судалгаа, хөгжлийн зардал гэж хүний мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдлэг шаардсан, бүтээлчээр ашиглах зорилгоор системтэйгээр гүйцэтгэсэн шинжилгээ судалгаа, хөгжлийн ажлын бүтээл, үр дүнгийн зардлыг ойлгоно.

$$\begin{array}{l} \text{Шинжилгээ, судалгаа,} \\ \text{хөгжлийн зардлын} \\ \text{ДНБ-д эзлэх хувь} \end{array} = \frac{\text{Шинжилгээ, судалгаа, хөгжлийн зардал}}{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн тайлан; ҮСХ-ны дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

4.2. Нийгмийн үзүүлэлтүүд

9. Ажилгүйдлийн түвшин

Үзүүлэлтийн тодорхойлолт: **Ажиллагч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж ойлгоно.

Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

$$\begin{array}{l} \text{Ажилгүйдлийн} \\ \text{түвшин} \end{array} = \frac{\text{Ажилгүй иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс улсын дүн, насны бүлэг, хүйс, бүсээр, жилээр тооцно.

10. Хөдөлмөрийн бүтээмж

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хөдөлмөрийн бүтээмж нь нэгж хөдөлмөрийн орцод ногдох гарц буюу ДНБ-ий хэмжээг илэрхийлнэ. Хөдөлмөрийн бүтээмжийг ҮСХ-ны даргын 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Бүтээмж тооцох аргачлал”-ын дагуу тооцно.⁵

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүн, Дотоодын нийт бүтээгдэхүүний зэрэгцүүлэх үнээрх тооцоонд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

11. Ядуурлын хамралтын хүрээ

Уг үзүүлэлтээр нийт хүн амын тоонд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн амын эзлэх хувь хэмжээг илэрхийлнэ.

$$P_0 = \left(\frac{1}{n}\right) \sum_{i=1}^q \left(\frac{z - y_i}{z}\right)^0 = \frac{q}{n}$$

y- хэрэглээ, i-хувь хүн, z-ядуурлын шугам, q-ядуурлын шугамаас доош хэрэглээтэй хүн амын тоо, n- эх олонлогт байгаа нийт хүн амын тоо

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: ҮСХ-ны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны үр дүнд үндэслэн улсын дундаж, бүс, суурьшлаар, 2 жил тутамд тооцно.

12. Ундны баталгаат усаар хангагдсан хүн амын эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ундны баталгаат усаар хангагдсан хүн амын эзлэх хувь нь нийт хүн амын дунд төвлөрсөн болон төвлөрсөн бус усан хангамж, хамгаалагдсан худаг, булаг шанднаас ундны усаа авч хэрэглэж чадахгүй байгаа хүн амын тоог хувиар илэрхийлнэ. Төвлөрсөн усан хангамж нь ус олборлох, цэвэрлэх, дамжуулах зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах систем болно.⁶

$$PP_{WASDWS} = \frac{P_{WASDWS}}{N_{mean}} \times 100$$

PP_{WASDWS} - Ундны баталгаат усаар хангагдсан хүн амын эзлэх хувь

P_{WASDWS} - Ундны баталгаат усаар хангагдсан хүн амын тоо

N_{mean} - Жилийн дундаж хүн ам

⁵ ҮСХ (2017), Бүтээмж тооцох аргачлал, хуудас.6

⁶ ҮСХ (2009), Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, хуудас.67

Хүн амын жилийн дундаж тоог тухайн оны эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг 2-т хувааж тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: ХАОСТ-оор 10 жил, Өрхийн түүвэр судалгаануудааас 3-5 жилийн давтамжтайгаар, захиргааны мэдээллээс жил бүр улсын дүн, бүс, аймаг, нийслэлээр тооцно.

13. Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь нь ялгадас зайлуулах эрүүл ахуйн шаардлага хангасан байгууламжаар хангагдсан хүн амын тоог хувиар илэрхийлнэ. Сайжруулсан ариун цэврийн байгууламжид ариутгах татуурга бүхий ариун цэврийн байгууламж, энгийн бөгөөд хамгаалагдсан, агааржуулалттай гадаа жорлонгоос төвлөрсөн муу усны хоолойд холбогдсон ус татах хураагууртай жорлон хамаарна. Ариутгах татуурга гэж хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээг хэлнэ.⁷

Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

$$PP_{\text{WAI SF}} = \frac{P_{\text{WAI SF}}}{N_{\text{mean}}} \times 100$$

$PP_{\text{WAI SF}}$ – Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь
 $P_{\text{WAI SF}}$ – Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоо
 N_{mean} – Жилийн дундаж хүн ам

Хүн амын жилийн дундаж тоог тухайн оны эхний болон эцсийн хүн амын тооны нийлбэрийг 2-т хувааж тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: ХАОСТ-оор 10 жил, Өрхийн түүвэр судалгаануудааас 3-5 жилийн давтамжтайгаар, захиргааны мэдээллээс жил бүр улсын дүн, бүс, аймаг, нийслэлээр тооцно.

4.3. Байгаль орчны үзүүлэлтүүд

14. Материал багтаамж: Материалын дотоодын хэрэглээ, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаагаар кг/төг-өөр илэрхийлэгдэнэ.

Үзүүлэлтийн тодорхойлолт: Материалын дотоодын хэрэглээ гэж тухайн жилд дотоодын эдийн засагт олборлож, ашигласан материалын нийт хэмжээг

⁷ ҮСХ (2009), Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, хуудас.69

харуулна. Уг үзүүлэлт нь эдийн засгийн эргэлтэд оруулсан материалын нийт орцыг харуулах бөгөөд материалын шууд орцоос экспортыг хасч тодорхойлно.

$$\begin{array}{l} \text{Материал} \\ \text{багтаамж} \end{array} = \frac{\text{Материалын дотоодын хэрэглээ}}{\text{Дотоодын нийт бүтээгдэхүүн}}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: БОЭЗДС-ийн материалын урсгалын данс; Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн тооцоонд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

15. Хүлэмжийн хийн ялгарал

Үзүүлэлтийн тодорхойлолт: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенц (Конвенц гэх)-ийн гол зорилго бол агаар мандал дах хүлэмжийн хийн агууламжийг тогтворжуулах ба түүнийг хүний буруутай үйл ажиллагаанаас болж уур амьсгалын тогтолцоонд сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй түвшинд барих явдал юм. Конвенцийн 4 ба 12 дугаар заалт, мөн Талуудын бага хурал (ТБХ)-ын холбогдох шийдвэрийн дагуу Конвенцийн Хавсралт 1-ийн орнууд нь Монреалын Протоколоор хянадаггүй хүлэмжийн хийг шингээх замаар арилгах, мөн хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй эх үүсвэрүүдийн ялгарлын хүлэмжийн хийн үндэсний тооллого (ХХҮТ)-ыг тооцож, конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт өгч байх үүрэг хүлээсэн байдаг. Мөн түүнчлэн Хавсралт 1-ийн орнууд конвенцид хүлээсэн үүргийнхээ дагуу ХХҮТ-ын мэдээллийг өөрсдийн 4 жил тутмын үндэсний тайлан-илтгэлдээ товч дүгнэлт маягаар тусгаж байхаар тогтсон байдаг. Конвенцийн 17 дугаар ТБХ-аар Хавсралт 1-ийн бус орнууд нь хоёр жил тутмын шинэчилсэн тайлангаа ХХҮТ-ын үр дүнгийн хамт хүргүүлэх шийдвэр гарсан (UNFCCC, 2014).

ХХҮТ нь тухайн улс орны нутаг дэвсгэрт хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй анхдагч эх үүсвэрээс ялгарсан ба шингээсэн (ой мод, тариалангийн газар гэх мэт) хүлэмжийн хийг тодорхойлж, тооцох зорилготой юм. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй анхдагч эх үүсвэрийн тоонд:

- цахилгаан, дулааны станц,
- том, дунд, бага чадлын дулааны болон дизель цахилгаан станц,
- ахуйн болон аж ахуйн нэгжийн зуух,
- дотоод шаталтын хөдөлгүүр бүхий бүх төрлийн тээврийн хэрэгсэл,
- үйлдвэрийн газар (цемент, шохой, ган төмөрлөгийн, архи ундааны зэрэг),
- мал сүрэг (малын амьсгал, ялгадсаас гарах хий),
- газар ашиглалт (газар тариалан, уул уурхай гэх мэт) болон ойн аж ахуй,
- хог хаягдал (хатуу хог хаягдал, бохир ус) гэх мэт орно.

Хүлэмжийн хийн ялгарлыг дараах 5 салбараар тооцно. Үүнд:

1. Эрчим хүч,
2. Аж үйлдвэр,
3. Хөдөө аж ахуй,
4. Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ой,
5. Хог хаягдал

Хүлэмжийн хийн ялгарлыг олон улсад батлагдсан Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын мэргэжилтний хороо (УАӨЗГМХ)-ны 2006 оны аргачлалын⁸ дагуу 1990 оныг суурь он болгон тооцно.

Хүлэмжийн хийн ялгаралд нүүрсхүчлийн хий (CO₂), метан хий (CH₄), азотлог исэл (N₂O) гэсэн үндсэн гурван хийнээс гадна, перфторт нүүрстөрөгч (PFCs), фторт нүүрсүстөрөгч (HFCs), зургаан фторт хүхэр (SF₆), мөн шууд бус хүлэмжийн хийнүүд болох азотын исэл (NO_x), нүүрстөрөгчийн дутуу исэл буюу угаарын хий (CO), хүхрийн давхар исэл (SO₂), метан бус дэгдэмхий органик нэгдэл (МБДОН)-ийг хамруулдаг. ХХҮТ-ын тоон мэдээлэл цуглуулахад учир дутагдалтай байдгаас үүдээд зарим шууд бус хийнүүдийн тооцоо гарах боломжгүй.

Хүлэмжийн хийн нийт ялгарлын үр дүнг үндэсний хэмжээнд Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн салбарыг оруулсан ба оруулаагүй гэж 2 байдлаар тооцож, мян.тн CO₂-эквивалент гэсэн нэгжээр илэрхийлнэ.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зохион байгуулдаг Хүлэмжийн хийн үндэсний тооллогын үр дүнгээс салбараар 2 жил тутамд авч тархаана.

16. Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн нийт дүнд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар гэж улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газрыг ойлгоно.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг ойлгоно.⁹

⁸ 2006 IPCC Guidelines for National Greenhouse Gas Inventories.

⁹ “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” Монгол Улсын 3 дугаар зүйлийн 3.1.1 заалт.

Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн хэмжээг усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайд харьцуулж тооцно.

$$\frac{\text{Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн нийт дүнд эзлэх хувь}}{\text{Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн хэмжээ, км}^3} = \frac{\text{Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн хэмжээ, км}^3}{\text{Усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбай, км}^3} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Усны нөөц, хомсдол, хамгаалалтын арга хэмжээний оны тайлан” БОХ-4.1, “Гол мөрний урсац эхийн нийт талбайн хэмжээ”-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

17. Хатаж ширгэсэн гол, горхи, булаг шанд, нуур тойрмын тоо

Үзүүлэлтийн тодорхойлолт: Усны тоо бүртгэл, гадаргын усны тооллогын дүн мэдээнд үндэслэн гаргасан хатаж ширгэсэн нуур, цөөрөм, гол, горхи, булаг, шандын тоог ойлгоно. Усны эх үүсвэрийн тоог (i) гол горхи; (ii) нуур цөөрөм; (iii) гол горхи; (iv) булаг шанд; (v) усан сан, хөв, цөөрөм гэж 5 ангилан гаргана.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Цэвэр усны нөөц, хомсдлын жилийн мэдээ” БОХ-4.1-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

18. Стандартын шаардлагад нийцэх түвшин хүртэл цэвэрлэсэн хаягдал усны нийт хаягдал усанд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: **Хаягдал ус** гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч байгаа бохир ус, шингэн хаягдлыг ойлгоно. **Стандартын шаардлагад нийцэх хүртэл түвшинд цэвэрлэсэн хаягдал ус** гэдэгт техникийн ерөнхий шаардлага MNS-4943 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл цэвэрлэсэн бохир усыг ойлгоно. Үзүүлэлтийг цэвэрлэх байгууламжаар дамжуулан стандартыг шаардлагад нийцэх түвшин хүртэл цэвэрлэсэн усны хэмжээг нийт хаягдал усны хэмжээнд харьцуулах байдлаар гаргана.

$$\frac{\text{Стандартын шаардлагад нийцэх түвшин хүртэл цэвэрлэсэн хаягдал усны нийт хаягдал усанд эзлэх хувь}}{\text{Стандартын шаардлагад нийцсэн түвшинд цэвэршүүлсэн хаягдал усны хэмжээ}} = \frac{\text{Стандартын шаардлагад нийцсэн түвшинд цэвэршүүлсэн хаягдал усны хэмжээ}}{\text{Нийт хаягдал усны хэмжээ}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Бохир ус цэвэрлэх байгууламжийн тайлан” БОХ-4.3-д үндэслэн улс, аймаг, нийслэлийн дүнгээр, жилээр тооцно.

19. Хот, суурин газрын агаар дах тоосонцорын агууламж (PM10, PM2.5)

Үзүүлэлтийн тодорхойрлолт: Хот, суурин газрын агаар дах тоосонцорын агууламж (PM10, PM2.5) гэж агаарт хатуу, шингэн төлөв байдалтай орших 2.5, 10 микрометрийн хэмжээтэй тоосонцорыг ойлгоно. 10 микрометрээс бага хэмжээтэй тоосны богино (1-24 цаг) ба урт хугацааны (хэдэн жилийн) нөлөөлөл нь уушги, зүрхний өвчлөл, нас баралтын нэг хүчин зүйл болдог. Зүрхний эсвэл уушгины өвчтэй хүмүүс, тухайлбал зүрхний архаг өвчтэй хүн, титэм судасны өвчтэй, гуурсан хоолойн багтраа өвчтэй хүн, өндөр настнууд (уушгины эсвэл зүрхний өвчингүй байж болно) тоосонд мэдрэмтгий байдаг. Зүрхний өвчтэй хүн тоосны нөлөөнд өртсөнөөс цээжээр хөндүүрлэх, чичрэх, амьсгал давхцах, сульдах, зүрхний хэмнэл алдагдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Тоос нь амьсгалын замын халдварт өвчний өртөмтгий байдлыг ихэсгэх бөгөөд амьсгалын замын архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Уг үзүүлэлтийг агаарын чанарын стандартын дагуу хүлцэх хэм хэмжээнээс давсан хэмжээгээр авна.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Агаарын чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Агаар дахь бохирдуулах бодисын агууламж мэдээ” ЦУ2-нд үндэслэн харуулын дүнгээр, жилийн дунджаар тооцно.

20. Хот, суурин газрын агаар дах хүхэрлэг хийн агууламж

Үзүүлэлтийн тодорхойрлолт: Хот, суурин газрын агаар дах хүхэрлэг хийн агууламж гэж өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхитэй ордог хийг ойлгоно. Энэ нь нүүрс, газрын тос зэрэг хүхэр агуулсан түлшний шаталт, металл боловсруулах үйл ажиллагаа зэргээс агаарт ялгардаг.

Фотоколорометрийн аргаар тодорхойлох: Сорьц авах үед шингээгч гуурс дундуур нэвтэрч гарсан агаарын эзэлхүүнийг доорх томъёог ашиглан хэвийн нөхцөл (760 мм мөнгөн усны баганын даралттай, 00С температуртай нөхцөлд)-д шилжүүлнэ.

$$U_0 = (U_t * 273 * P_t) / ((273 + t) * 760)$$

U_0 : хэвийн нөхцөлд шилжүүлсэн агаарын сорьцын эзэлхүүн /л/

$U_t - P_t$: Т – температуртай байхад авсан агаарын сорьцын эзэлхүүн /л/

P_t – сорьц авах үеийн агаарын даралт

T – сорьц авах үеийн агаарын температур

Шингээгч гуурс дундуур нэвтэрсэн агаар дахь азотын давхар ислийн агууламжийг доорхи томёогоор олно.

$$C_{so2}=(1.2K_{so2}*D)/U0$$

K_{so2} - Жиших тахирмагаас олсон коэффициент

D – Фотоколориметрийн багажаар тодорхойлсон гэрлийн нягт

C_{so2} - Агаар дахь хүхэрлэг хийн агууламж мг/м³

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Агаарын чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Агаар дахь бохирдуулах бодисын агууламж мэдээ” ЦУ2-нд үндэслэн харуулын дүнгээр, жилийн дунджаар тооцно.

21. Хот, суурин газрын азотын давхар ислийн агууламж

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хот, суурин газрын агаар дах азотын давхар ислийн агууламж гэж өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхитэй ордог хийг ойлгоно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Агаарын чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Агаар дахь бохирдуулах бодисын агууламж мэдээ” ЦУ2-нд үндэслэн харуулын дүнгээр, жилийн дунджаар тооцно.

22. Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь гэж дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг нийт цуглуулсан хог хаягдалд харьцуулсан харьцааг ойлгоно. Хог хаягдлын хэмжээ гэж хэрэглээний болон үйлдвэрлэл, үйлчилгээний явцад бий болж, цаашид тухайн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон эд юмсыг хог хаягдал гэж үзнэ.

$$\text{Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь, \%} = \frac{\text{Дахин боловсруулсан хог хаягдал}}{\text{Нийт цуглуулсан хог хаягдал}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэн гаргадаг “Хатуу хог хаягдлын 20... оны жилийн мэдээ” БОХ-7.1, “Хог хаягдлын дахин боловсруулалтын 20... оны жилийн мэдээ” БОХ-7.2-нд үндэслэн аймаг, нийслэл, улсын дүнгээр, жилээр тооцно.

23. Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн нийт хот тосгон, бусад суурин газрын талбайд эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ногоон байгууламжийн талбай гэж суурин газрын нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж, талбай, том, дунд, жижиг /бичил/ хамгаалалтын зурвас, мөн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, орон сууцны хорооллын доторх ногоон байгууламж болон ногоон байгууламж бүхий бусад цэцэрлэгжсэн нийт талбайгаар ойлгоно.

Уг үзүүлэлтийг тооцохдоо хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн хэмжээг газрын нэгдмэл сангийн хот, суурин газрын ангиллын хүрээнд гаргасан хот тосгон, бусад суурин газрын нийт талбайн хэмжээнд харьцуулж тооцно.

$$\frac{\text{Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн нийт хот, тосгон, бусад суурин газрын эзлэх хувь, \%}}{\text{Хот тосгон, бусад суурин газрын нийт талбай}} = \frac{\text{Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбай}}{\text{Хот тосгон, бусад суурин газрын нийт талбай}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Нийслэлийн Засаг даргын 2005 оны 475 дугаар захирамжаар баталсан захиргааны статистикийн “Ногоон байгууламжийн бүртгэл” маягт ХТМС-2, “Ургамлын хашлагын бүртгэл” ХТМС-1, “20.. оны улиралд тарьсан мод, сөөгний мэдээ” ХТМ-2 маягтад үндэслэн аймаг, нийслэлээр жилээр тооцно.

24. Тусгай хамгаалалттай газрын Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь

Үзүүлэлтийн тодорхойлолт: Улсын тусгай хамгаалалттай газар нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авсан газар нутгийг хэлнэ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн дагуу УИХ-ын тогтоолоор дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авсан газар; аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийг хамруулан тооцож мян.га-гаар илэрхийлэн ойлгоно.

$$\frac{\text{Тусгай хамгаалалттай газрын Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь}}{\text{Тусгай хамгаалалттай газрын хэмжээ, мян.га}} = \frac{\text{Тусгай хамгаалалттай газрын хэмжээ, мян.га}}{\text{Монгол Улсын нийт нутаг дэвсгэр, мян.га}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Газрын нэгдсэн сангийн тайлан” ГТ-1-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

25. Ойгоор бүрхэгдсэн газрын эзлэх хувь буюу ойрхог чанар

Үзүүлэлтийн тодорхойлолт: Ойгоор бүрхэгдсэн газар гэж хэвийн ургаж байгаа байгалийн ой, таримал ой, гол мөрний дагуух сөөг, торлог, бургас бүхий газрыг ойлгоно.

$$\frac{\text{Ойгоор бүрхэгдсэн газрын эзлэх хувь буюу ойрхог чанар}}{\text{Ойгоор бүрхэгдсэн газрын хэмжээ, мян.га}} = \frac{\text{Ойгоор бүрхэгдсэн газрын хэмжээ, мян.га}}{\text{Монгол Улсын нийт нутаг дэвсгэр, мян.га}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэн гаргадаг “Ойн нөөц, түүний хамгаалалт, нөхөн сэргээлт, ашиглалтын жилийн мэдээ” БОХ-5-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

26. Хохирол учирсан газрын Монгол Улсын нийт газар нутагт эзлэх хувь (%)

Үзүүлэлтийн тодорхойлолт: Хохирол учирсан газар гэж салхи, усны эвдрэлд орсон, үржил шим нь буурсан, мэрэгчид, хортон шавьжинд нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон, онц аюултай хог ургамалд нэрвэгдсэн тариалангийн газар; талхлагдсан, намагжсан, элсний нүүлтэд орсон, цөлжсөн, ашигт малтмалын олборлолтонд өртсөн, газрын тосны олборлолтоос бохирдсон, ургамлан бүрхэвчгүй болсон бэлчээрт ба бусад өвслөг ургамалт газар; элсний нүүлтэд орсон, химийн болон цацраг идэвхт бодисоор хордсон, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон, ахуйн хог хаягдлаар бохирдсон хот тосгон, бусад суурин газар; түймэрт нэрвэгдсэн, өвчин, хортон шавьжид идэгдсэн, мод, бут, сөөг, загийг устгасан, ашигт малтмалын олборлолтонд өртсөн ойн сан бүхий газар; гадаргын болон гүний ус бохирдсон, үйлдвэрийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар, ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар зэрэг усны сан бүхий газар; геологийн эрэл хайгуулын ажил, ашигт малтмалын олборлолт, батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажил, зам тээвэр холбооны барилга

засвар, үйлчилгээний ажлаас шалтгаалан хохирсон ухагдаж эвдэрсэн газар болно.

$$\begin{array}{l} \text{Хохирол учирсан} \\ \text{газрын Монгол} \\ \text{Улсын нийт газар} \\ \text{нутагт эзлэх хувь} \end{array} = \frac{\text{Хохирол учирсан газрын хэмжээ}}{\text{Монгол Улсын газар нутгийн хэмжээ}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Газарт учруулсан хохирлын тайлан” ГТ-6-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

27. Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд орсон нутаг дэвсгэрийн Монгол Улсын нийт газар нутагт эзлэх хувь (%)

Үзүүлэлтийн тодорхойлолт: Цөлжилт гэж уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хуурай, хуурайвтар, чийг дутмаг бүс нутгийн хөрсний үржил шим устаж доройтсоныг ойлгоно. Цөлжилтөд өртсөн нутаг дэвсгэрийг БОАЖ-ын сайдын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/391 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын зэрэглэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох аргачлал”-ын дагуу тооцно.¹⁰

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн; Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн тайланд үндэслэн улсын дүнгээр таван жил тутам тооцно.

28. Нөхөн сэргээсэн хөдөө аж ахуйн газрын хохирол учирсан нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь

$$\begin{array}{l} \text{Нөхөн сэргээсэн} \\ \text{хөдөө аж ахуйн} \\ \text{газрын хохирол} \\ \text{учирсан нийт} \\ \text{нутаг дэвсгэрт} \\ \text{эзлэх хувь} \end{array} = \frac{\text{Нөхөн сэргээсэн хөдөө аж ахуйн газрын хэмжээ}}{\text{Хохирол учирсан нийт талбай}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Газарт учруулсан хохирлын тайлан” ГТ-6-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

¹⁰ БОАЖЯ (2015), Хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдлын зэрэглэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох аргачлал х1-6

29. Ашигт малтмалын олборлолтод өртсөн газрын хохирол учирсан нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь (%)

$$\begin{array}{l} \text{Ашигт малтмалын} \\ \text{олборлолтод} \\ \text{өртсөн талбайн} \\ \text{хохирол учирсан} \\ \text{нийт нутаг} \\ \text{дэвсгэрт эзлэх} \\ \text{хувь} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Ашигт малтмалын олборлолтод өртсөн} \\ \text{газрын хэмжээ} \end{array}}{\text{Хохирол учирсан нийт талбай}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Газарт учруулсан хохирлын тайлан” ГТ-6-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

30. Цомхотгосон болон тэг элдэншүүлэгийн технологи нэвтрүүлсэн талбайн хэмжээ үр тарианы нийт талбайд эзлэх (%)

Үзүүлэлтийн тодорхойлолт: Цомхотгосон талбай гэж тариалалт, уриншийн механик боловсруулалтын тоог цөөлж нэг удаагийн явалтаар уринш бэлтгэх хэд хэдэн үйлдлийг зэрэг гүйцэтгэхийг хэлнэ.

Тэг элдэншүүлэлтийн талбай гэж уринш бэлтгэхдээ хөрсийг хөдөлгөлгүй буюу хөрсөнд механик боловсруулалт хийлгүй химижүүлэн боловсруулалт хийн бэлтгэсэн талбайг ойлгоно.

$$\begin{array}{l} \text{Цомхотгосон болон} \\ \text{тэг элдэншүүлэгийн} \\ \text{технологи} \\ \text{нэвтрүүлсэн} \\ \text{талбайн хэмжээ үр} \\ \text{тарианы нийт} \\ \text{талбайд эзлэх хувь} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Цомхотгосон болон тэг элдэншүүлэгийн} \\ \text{технологи нэвтрүүлсэн талбай} \end{array}}{\text{Үр тарианы нийт талбай}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Газрын нэгдсэн сангийн тайлан” ГТ-1, Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Ургацын баланс”-д үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

31. Бэлчээрийн даац

Үзүүлэлтийн тодорхойлолт: Бэлчээрийн даац гэж хадлан, бэлчээрийн талбайн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулсанаар ойлгоно.¹¹

¹¹ УСХ (2015), Хөдөө аж ахуйн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, хуудас.16

$$\text{Бэлчээрийн даац} = \frac{\text{Бэлчээрийн талбайн хэмжээ}}{\text{Хонин толгойд шилжүүлсэн малын тоо}}$$

100га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоог дараах томъёогоор тооцно.

$$\text{100 га талбайд ногдох малын тоо} = \frac{\text{Бэлчээрийн талбайн хэмжээ}}{\text{Хонин толгойд шилжүүлсэн малын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Газрын нэгдсэн сангийн тайлан” ГТ-1, жилийн эцсийн мал тооллогын үр дүнд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

32. Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO-14001 стандартыг хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо (%)

Үзүүлэлтийн тодорхойлолт: Байгаль орчны стандарт ISO-14001 нь байгаль орчны менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хөгжүүлэх сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагуудад олгодог олон улсын стандарт юм.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж, задаргаа: Стандарт хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын жилийн лавлагаа”-нд үндэслэн улсын дүнгээр, жилээр тооцно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] Агаарын чанарын статистик мэдээллийн ойлголт, тодорхойлолт <http://agaar.mn/index>
- [2] Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 тоот тогтоолын хавсралт “Ногоон хөгжлийн бодлого”
- [3] НҮБСХ, “Ногоон эдийн засагт шилжих явцыг үнэлэх нь” төсөл (2014-2015), “Хөгжиж буй орнуудад зориулсан Ногоон хөгжлийн үзүүлэлтийн жагсаалт”, Нью-Йорк
- [4] НҮБ-ын ЭЗХАХБ (2011), Ногоон өсөлтөд шилжих үйл явцыг үнэлэх ЭЗХАХБ-ын үзүүлэлтүүд
- [5] НҮБ-ын ЭЗХАХБ (2014), Ногоон өсөлтийн үзүүлэлтүүд
- [6] НҮБСХ (2011), Олон улсын эрчим хүчний статистикийг тооцох зөвлөмж, Нью-Йорк
- [7] БОАЖЯ (2015), Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- [8] МУ-ын ҮСХ-ны даргын 2010 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1/173 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”
- [9] МУ-ын ҮСХ-ны даргын 2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 1/134 тоот тушаалын хавсралт “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал”
- [10] МУ-ын ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/135 тоот тушаалын хавсралт “Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”
- [11] МУ-ын ҮСХ-ны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 6 дугаар сарын 16, 19-ны өдрийн 01/68/94 тоот тушаалын хавсралт “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”
- [12] МУ-ын ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/135 тоот тушаалын хавсралт “Эрүүл аюулгүй байдлын индекс тооцох аргачлал”
- [13] Монгол Улсын Засгийн Газрын 2003 оны 204 тоот тогтоолын хавсралт “Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлангийн маягт батлах тухай”
- [14] Монголын Ногоон Барилгын хүрээлэн (2014), “Ногоон барилгын зэрэглэл тогтоох үнэлгээний систем” <http://www.mne.mn/mn/news/show/2079> цахим хуудас
- [15] МУ-ын ҮСХ-ны даргын 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/77 тоот тушаалын хавсралт “Материалын урсгалын дансыг байгуулах аргачлал”
- [16] МУ-ын ҮСХ-ны даргын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/142 тоот тушаалын хавсралт “Хөдөө аж ахуйн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”

- [17] МУ-ын ҮСХ-ны даргын 2017 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А/04 тоот тушаалын хавсралт “Бүтээмж тооцох аргачлал”
- [18] “Байгаль орчныг хамгаалах тухай” Монгол Улсын хууль
- [19] “Газрын тухай” Монгол Улсын хууль
- [20] “Усны тухай” Монгол Улсын хууль

Хавсралт 1.

Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтийн жагсаалт

№	Үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр	Давтамж	Задаргаа	Мэдээллийн боломжит байдал
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
1	Эрчим хүчний багтаамж	Эрчим хүчний данс (ҮСХ)	Жилээр	Салбараар	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
2	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	Жилийн тайлан (ЭХЯ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
3	Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний боловсруулалтын хувь	Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын 20... оны ...-р сарын мэдээ-ААҮ1 (ҮСХ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
4	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Үндэсний тооцоо (ҮСХ)	Жилээр	Салбараар	Тархаагдаж байгаа
5	Аялал жуулчлалын салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Үндэсний тооцоо (ҮСХ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
6	Ногоон хөгжил болон байгаль орчныг хамгаалах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Үндэсний тооцоо; БО-ны хамгаалах зардлын судалгаа (ҮСХ); Байгаль хамгаалах арга хэмжээ, ногоон хөгжилд зарцуулсан зардлын жилийн тайлан (БОАЖЯ)	3 жил тутам	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
7	Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын Засгийн газрын зардалд эзлэх хувь	Онцгой байдлын ерөнхий газрын тайлант жилийн Санхүүгийн тайлан (ОБЕГ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
8	Ногоон болон тогтвортой хөгжил дэмжсэн худалдан авалтын төрийн нийт худалдан авалтанд эзлэх хувь	Сангийн яам	Жилээр	Улсын дүнгээр	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
9	Шинжилгээ, судалгаа, хөгжлийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Үндэсний тооцоо (ҮСХ), Боловсролын статистик	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

Ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийг тооцох аргачлал

№	Үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр	Давтамж	Задаргаа	Мэдээллийн боломжит байдал
		мэдээлэл (БСШУЯ)			
10	Барилгын дулаан алдагдлын бууралтын хувь	БХБЯ	Жилээр	Улсын дүнгээр	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
11	Нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон зорчигчдын нийт зорчигчдод эзлэх хувь	Нийслэлийн тээврийн газар, “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын тайлан, Авто, усан замын тээврийн 20... оны ...-р сар, улирлын тээвэрлэлтийн мэдээ Т1	Улирлаар	Улсын дүнгээр	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
12	Нийт тээврийн хэрэгсэлд ногоон нийтийн тээврийн хэрэгслийн эзлэх хувь	Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн тээврийн газар, “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын тайлан	Жилээр	Улсын дүнгээр	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
13	Ногоон ажлын байрны тоо	Ажиллах хүчний судалгаа (ҮСХ)	Жилээр	Салбараар	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
14	Ажилгүйдлийн түвшин	Ажиллах хүчний судалгаа (ҮСХ)	Жилээр	Насны бүлэг, хүйс, бүс	Тархаагдаж байгаа
15	Хөдөлмөрийн бүтээмж	Ажиллах хүчний судалгаа, Үндэсний тооцоо (ҮСХ)	Жилээр	Улсын дүнгээр	Тархаагдаж байгаа
16	Ядуурлын хамралтын хүрээ	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ҮСХ)	Жилээр	Улсын дундаж, бүс, байршлаар	Тархаагдаж байгаа
17	Ундны баталгаат усаар хангагдсан хүн амын эзлэх хувь	ХАОСТ, Хүүхэд хөгжлийн судалгаа (ҮСХ)	5, 10 жил тутам	Улсын дүн	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
18	Сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	ХАОСТ, Хүүхэд хөгжлийн судалгаа (ҮСХ))	5, 10 жил тутам	Улсын дүн	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

Ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийг тооцох аргачлал

№	Үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр	Давтамж	Задаргаа	Мэдээллийн боломжит байдал
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
19	Материал багтаамж	Үндэсний тооцоо	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
20	Дотоодын нийт бүтээдэхүүнд ногдох материалын нийт ул мөр (footprint)	Материал урсгалын данс	Жилээр	Дүүргээр	Арга зүй, ойлголт, тодорхойлолт, мэдээллийн эх үүсвэр байхгүй
21	Хүлэмжийн хийн ялгарал	Хүлэмжийн хийн үндэсний тооллого (БОАЖЯ)	2 жил тутам	Салбараар	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
22	Тусгай хамгаалалтад авсан усны нөөц бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн нийт дүнд эзлэх хувь	Усны нөөц, хомсдол, хамгаалалтын арга хэмжээний оны тайлан БОХ-4.1, Гол мөрний урсац эхийн нийт талбайн хэмжээ (БОАЖЯ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
23	Хатаж ширгэсэн гол, горхи, булаг шанд, нуур тойрмын тоо	Цэвэр усны нөөц, хомсдлын жилийн мэдээ БОХ-4.1 (БОАЖЯ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
24	Стандартын шаардлагад нийцэх түвшин хүртэл цэвэрлэсэн хаягдал усны нийт хаягдал усанд эзлэх хувь	Бохир ус цэвэрлэх байгууламжийн тайлан БОХ-4.3 (БОАЖЯ)	Жилээр	Улс, аймаг, нийслэлийн дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
25	Хот, суурин газрын агаар дах тоосонцорын агууламж (PM10, PM2.5)	Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж мэдээ ЦУ-2 (ЦУОШГ)	Жилийн дундаж	Харуулын дүнгээр	Тархаагдаж байгаа
26	Хот, суурин газрын агаар дахь хүхэрлэг хийн агууламж	Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж мэдээ ЦУ-2 (ЦУОШГ)	Жилийн дундаж	Харуулын дүнгээр	Тархаагдаж байгаа
27	Хот, суурин газрын азотын давхар ислийн агууламж	Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж мэдээ ЦУ-2 (ЦУОШГ)	Жилийн дундаж	Харуулын дүнгээр	Тархаагдаж байгаа
28	Хог хаягдлын дахин боловсруулалтын хувь	Хатуу хог хаягдлын 20... оны жилийн мэдээ БОХ-7.1, Хог хаягдлын дахин боловсруулалтын 20... оны жилийн мэдээ БОХ-7.2 (БОАЖЯ)	Жилээр	Улсын дүн	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

Ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийг тооцох аргачлал

№	Үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр	Давтамж	Задаргаа	Мэдээллийн боломжит байдал
29	Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн нийт хот тосгон, бусад суурин газрын талбайд эзлэх хувь	Ногоон байгууламжийн бүртгэл” маягт ХТМС-2, “Ургамлын хашлагын бүртгэл ХТМС-1, 20.. оны улиралд тарьсан мод, сөөгний мэдээ ХТМ-2 маягт (НЗДТГ)	Жилээр	Хот, суурин газрын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
30	Тусгай хамгаалалттай газрын Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Газрын нэгдсэн сангийн тайлан-ГТ-1 (ГЗБГЗЗГ)	Жилээр	Улсын дүн	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
31	Ойгоор бүрхэгдсэн газрын эзлэх хувь буюу ойрхог чанар	“Ойн нөөц, түүний хамгаалалт, нөхөн сэргээлт, ашиглалтын жилийн мэдээ” БОХ-5 (БОАЖЯ)	Жилээр	Улсын дүн	Тархаагдаж байна
32	Хохирол учирсан газрын Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Газрын нэгдсэн сангийн тайлан-ГТ-1; Газарт учруулсан хохирлын тайлан-ГТ-6 (ГЗБГЗЗГ)	Жилээр	Улсын дүн	Тархаагдаж байгаа
33	Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд орсон нутаг дэвсгэрийн Монгол Улсын нийт газар нутагт эзлэх хувь	Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн, газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн тооцоо	5 жил тутам	Улсын дүн	Тархаагдаж байгаа
34	Нөхөн сэргээсэн хөдөө аж ахуйн газрын хохирол учирсан нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь	Газарт учруулсан хохирлын тайлан-ГТ-6 (ГЗБГЗЗГ)	Жилээр	Улсын дүн	Тархаагдаж байгаа
35	Ашигт малтмалын олборлолтод өртсөн газрын хохирол учирсан нутаг дэвсгэрт эзлэх хувь	Газарт учруулсан хохирлын тайлан-ГТ-6 (ГЗБГЗЗГ)	Жилээр	Улсын дүн	Тархаагдаж байгаа
36	Цомхотгосон болон тэг элдэншүүлэгийн технологи нэвтрүүлсэн талбайн хэмжээ үр тарианы нийт талбайд эзлэх	Газрын нэгдсэн сангийн тайлан-ГТ-1 (ГЗБГЗЗГ); Ургацын баланс (ХХААХҮЯ)	Жилээр	Улсын дүн	Албан ёсоор тархаагдаагүй байгаа
37	Бэлчээрийн даац	Жилийн эцсийн мал тооллого (ҮСХ), Газрын нэгдсэн сангийн тайлан-ГТ-1 (ГЗБГЗЗГ)	Жилээр	Улсын дүн	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

Ногоон хөгжлийг тодорхойлох үзүүлэлтийг тооцох аргачлал

№	Үзүүлэлт	Мэдээллийн эх үүсвэр	Давтамж	Задаргаа	Мэдээллийн боломжит байдал
38	Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO-14001 стандартыг хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Стандарт хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжийн бүртгэлийн тайлан (БОАЖЯ)	Жилээр	Улсын дүнгээр	Албан ёсоор тархаагдаагүй байгаа

Хавсралт 2.

**Ногоон хөгжлийн үндсэн үзүүлэлтийг хариуцан
гаргах ажилтнуудын жагсаалт**

№	Овог, нэр	Байгууллагын нэр, албан тушаал	Харилцах утас
1	Р.Ягаанцэцэг	НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн	327199
2	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын мэргэжилтэн	
3	Д.Сүхбат	Ногоон байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	315333
4	Д.Батхуяг	ХААХҮЯ- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн	261691, 99015010
5	Б.Одонхүү	ХААХҮЯ -Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн	263408, 99873957
6	Н.Бямбадорж	ХААХҮЯ -Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	263247, 99009921
8	Ч.Долгорсүрэн	ХААХҮЯ - Бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн	260709, 99067861
9	А.Түвшинбаатар	ОБЕГ-ын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, ахмад	263583, 99062302
10	Б.Ачитсайхан	УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн	263023
11	Г.Дуламсүрэн	Нийслэлийн тээврийн газар Эдийн засаг, статистикийн мэргэжилтэн	327259
12	Х.Мөнхбат	ЭХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Сэргээгдэх эрчим хүчний хэлтсийн мэргэжилтэн	62-263057
13	П.Гэрлээ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар - Газар зохион байгуулалтын хэлтэс, мэргэжилтэн	264592
14	Б.Дөл	Газар зохион байгуулалтын хэлтэс, мэргэжилтэн	264596
15	Р.Отгончимэг	Инженер хайгуул мониторингийн хэлтэс, ахлах мэргэжилтэн	263676
16	Д.Мөнхцэцэг	Инженер хайгуул мониторингийн хэлтэс, мэргэжилтэн	263676
17	Н.Мөнхөө	Газар зохион байгуулалтын хэлтэс, ахлах мэргэжилтэн	264596
18	Ө.Одгэрэл	ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн ахлах мэргэжилтэн	99110219
19	С.Эрдэнэцэцэг	БОАЖЯ-ны ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах мэргэжилтэн	325848, 99194971